



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/139

Улаанбаатар хот

Дугаар хүчинтэйд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь хэсэг, "Агентлаг байгуулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 222 дугаар "Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоол, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын хамтран баталсан 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 22/02, 22/01 дугаартай "Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас мэргэжлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах гэрээ"-ний 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/113 дугаар тушаалаар "Хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгох журам" батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Журам батлах тухай" А/139 дугаар тушаалаар улсын хэмжээнд эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, оношилгоо, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын баталсан "Эмнэлэг, эм хангамжийн байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр"-ийн дагуу зөвлөн туслах үйлчилгээг эхлүүлсэн тул зайлшгүй шаардлагаар 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд хяналт шалгалтын баримт бичигт олгосон дугаарыг хүчинтэйд тооцсугай.

2. Хүчинтэйд тооцсон хяналт шалгалтын баримт бичигт олгосон дугаарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын хяналтын газар (Г.Номин), Захиргаа, дирдлагын газар (Б.Батбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Д.НАРАНТУУЯА



1422 010139